

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БАТЛАВ:
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ДЭД САЙД

Д.ЗАГДЖАВ

2020 оны 2-р сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2020/16

**МОНГОЛ ОРНЫ М (N) ХАВТГАЙН ХЭМЖЭЭНД ХИЙГДСЭН
УЛСЫН ГЕОЛОГИЙН 1:200000-НЫ МАСШТАБТАЙ ИЖ БҮРДЭЛ ЗУРГУУДЫГ
2020-2023 ОНД НЭГТГЭХ ТӨСЛИЙН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат:	Монгол орны М (N) хавтгайн хэмжээнд хийгдсэн УГЗ-200 иж бүрдэл зургийг нэгтгэх
Судалгааны хүрээ:	Улсын геологийн 1:200000-ны масштабтай иж бүрдэл зургуудыг нэгтгэж, мэдээллийг боловсронгуй болгох
Ашигт малтмалын төрөл:	Бүх төрлийн ашигт малтмал
Судалгааны талбайн нэр:	Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Төв, Хэнтий, Дорнод аймгуудын ихэнх нутгийг хамарсан талбайд
Судалгааны талбайн хэмжээ:	504,222.97 кв.км
Хавтгай:	M-45-XXIII, XXIV, XXVIII, XXIX, XXX, XXXIV, XXXV, XXXVI; M-46-VIII, IX, X, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI; N-47-XXXIII, XXXIV; M-47-II, III, IV, V, VI, VIII, IX, X, XI, XII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI; M-48-I, VII, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI; M-49-XVIII, XIX, XX, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI; M-50-XIII, XIV, XV, XIX, XX, XXI, XXV, XXVI, XXVII, XXXI, XXXII, N-47-XXXIII, XXXIV.
Код:	УГЗ-200-M-2020

1. Геологийн даалгавар өгөх үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.4 дэх хэсгийн 1 дэх зорилт, Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.59 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 5.1 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө” зэрэг бодлого, хууль, тогтоомж, тушаалыг тус тус үндэслэв

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судалгааны түвшин: Нэгтгэх М-45, 46, 47, 48, 49, 50, N-47 хавтгайнууд нь бүхэлдээ УГЗ-200 иж бүрдэл зураг зохиох ажлаар бүрхэгдсэн ч өөр хоорондоо хил зааг болон насны хувьд зөрүүтэй асуудлууд нилээдгүй байдаг. Эдгээр хавтгайнуудын хэмжээнд 2004-2020 онуудын хооронд нийт УГЗ-200 иж бүрдэл зураг зохиох төслүүд (фондын 5863, 5734, 5735, 5736, 6227, 8120, 8450, 7400, 6320, 5862, 5733, 5562, 5563, 5564, 5565, 5566, 5567, 5568 дугаартай) хэрэгжсэн.

Уг хавтгайнуудын тодорхой хэсэгт геофизикийн судалгаа хийгдсэн ба үүнд 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглал, 1:100000-ны болон 1:50000-ны масштабтай агаарын геофизикийн иж бүрэн зураглал, 1:25000-ны масштабтай цахилгаан хайгуулын судалгааны ажлуудад хийгдсэн. Эдгээр хавтгайнуудын хэмжээнд 2004-2018 онуудын хооронд нийт УГЗ-200 иж бүрдэл зураг зохиох төслүүдийн гүйцэтгэсэн нэгтгэл зургийн хоорондийн хил зааг, стратиграфийн нэгжүүд болон гүний чулуулгуудын нэршил, тектоник, металлогений бүс дүүргүүдийг нэгтсэн ангилалд оруулах, зөрүүтэй асуудлыг шийдэх, тухайн төслийн түвшинд шийдэх боломжгүй асуудлыг дараагийн судалгааны ажилд шийдүүлэхээр зөвлөмж гаргах, талбайг оновчтой сонгох боломжийг бүрдүүлнэ.

3. Ажлын зорилго:

Монгол Улсын Засгийн газраас уул, уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбараар тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж байгаа билээ. Иймд уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжлийн үндэс суурь болсон геологи, эрдэс баялгийн судалгааны олон жилийн үр дүнг нэгтгэн олон улсын жишгээр, хэрэглэгчийн шаардлагад нийцсэн мэдээллийг бэлтгэх шаардлага гарч байна.

Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэн боловсруулах суурь судалгааны ажил нь нэгдүгээрт Монгол Улсын нутаг дэвсгэрийн жижиг (1:500000, 1:1000000, 1:1500000) масштабын геологи, ашигт малтмал, металлогенийн зураг боловсруулах тулгуур эх баримт бүрдүүлэх, хоёрдугаарт, эдийн засгийн томоохон үр ашигтай ашигт малтмалын орд бүхий хүдрийн талбай олдох боломжтой хүдрийн талбай шинээр тодорхойлж, тухайн талбайн геологи-структур, геодинамик хөгжлийн ерөнхий төсөөлөл боловсруулах, гуравдугаарт, шинээр олж тодорхойлсон хүдрийн талбайд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр 1:50000-ны масштабын геологийн зураглал, ашигт малтмалын эрлийн ажлыг төлөвлөх, боловсруулахад оршино.

4. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал, дэс дараалал:

А. Бэлтгэл үе:

- М хавтгайн хэмжээнд хийгдсэн УГЗ-200 иж бүрдэл зургуудыг нэгтгэх М-45- XXIII, XXIV, XXVIII, XXIX, XXX, XXXIV, XXXV, XXXVI, М-46-VIII, IX, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, N-47-XXXIII, XXXIV, М-47-II, III, IV, V, VI, VIII, IX, X, XI, XII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, М-48-I, VII, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI; М-49-XVIII, XIX, XX, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, М-50-XIII, XIV, XV, XIX, XX, XXI, XXV, XXVI, XXVII, XXXI, XXXII, N-47-XXXIII, XXXIV хавтгайнууд нь 1:200000-ны масштабтай геологийн зураглалын ажлаар бүрхэгдсэн ч эдгээр хавтгайнуудын хэмжээнд янз бүрийн цаг хугацаанд хийсэн харилцан адилгүй үе шатны геологийн судалгааны тайлан, 1:200000-ны масштабын агаарын соронзон зураглал, 1:100000-ны масштабтай агаарын геофизикийн иж бүрэн зураглалын судалгааны ажлуудын үр дүнг ашиглан өмнөх зургуудын нэгтгэлийн чанар, агуулгыг сайжруулан боловсруулан региональ зүй тогтлуудыг гаргах ажлуудыг хийх,
- Геологийн бүх шатны судалгааны ажилтай танилцаж, холбогдох мэдээллийг зураг болон тоон хэлбэрээр цуглуулж ажлын зураг бэлтгэх,
- Геологийн бүх шатны судалгааны ажилд тулгуурлан зургийн нэгдсэн таних тэмдгийг зохиож мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлэх,
- Бүх мэдээллийг нэгтгэн дүгнэж зурган хэлбэрт оруулан, нэг ижил масштабтай болгон хөрвүүлж, зургийн эхийг бэлтгэх,
- Хил заагийн зөрүүтэй, өмнөх судалгаагаар шийдвэрлэгдээгүй маргаантай асуудлуудыг ялгаж, түүнийг шийдвэрлэх зорилгоор Монголын стратиграфийн комисс, Редакцийн зөвлөл болон мэргэжлийн хүмүүстэй уулзалт хийх, зөвөлгөө авах,
- Зураг зохиох явцад хурдас чулуулгын хил, насны зөрүүтэй асуудлуудыг шийдэх зорилгоор хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэх,
- Хээрийн судалгааны ажлаар үнэмлэхүй насны, палеонтологийн болон холбогдох дээж, сорьцуудыг авах,
- Судалгааны ажлаар авсан дээж, сорьцыг гадаад, дотоодын итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлэх,
- Бэлэн болсон зургуудад дагалдах тайлбар бичгийг зохиох,
- Зураг зохиох, дагалдах мэдээллийн сан бэлтгэх талбайн хэмжээнд Геологийн мэдээллийн төвд байгаа болон эрдэм шинжилгээний судалгааны материалуудтай танилцан судлах, дүгнэлт гаргах,
- Судалгааны болон боловсруулалтын ажлын арга аргачлал, ажлын хэмжээ, төсөл хэрэгжүүлэх геологчдын тоо, тэдгээрийн үндсэн үүрэг, ажлын дэс дараалал, ажлын эцсийн үр дүн, төсөвт өртгийг нарийвчлан тусгасан төсөл, төсвийг зохих журмын дагуу боловсруулж батлуулах,
- Төсөл хэрэгжүүлэх явцад геологийн маргаантай асуудлуудыг шийдвэрлэх, шалган баталгаажуулах зорилгоор хийх хээрийн судалгааг ажлын төрөл, тоо хэмжээгээр гарган төсөл төсөвт нарийвчлан тусгах.

Б. Үндсэн ажлын үе:

1. М-45- XXIII, XXIV, XXVIII, XXIX, XXX, XXXIV, XXXV, XXXVI, М-46-VIII, IX, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, N-47-XXXIII, XXXIV, М-47-II, III, IV, V, VI, VIII, IX, X, XI, XII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, М-48-I, VII, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, XIX, XX, XXI, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI,; М-49-XVIII, XIX, XX, XXII, XXIII, XXIV, XXV, XXVI, XXVII, XXVIII, XXIX, XXX, XXXI, XXXII, XXXIII, XXXIV, XXXV, XXXVI, М-50-XIII, XIV, XV, XIX, XX, XXI, XXV, XXVI, XXVII, XXXI, XXXII, N-47-XXXIII, XXXIV хавтгайнуудын хэмжээнд УГЗ-200 иж бүрдэл зургуудыг нэгтгэх, хэвлэлтэнд бэлтгэх зааварт тусгасны дагуу дараах үндсэн зургуудыг М (N) хавтгайн хэмжээнд нэгтгэсэн 1:200000-ны масштабтайгаар, дагалдах тойм зургуудыг 1:500000-ны масштабтайгаар иж бүрдлээр нэгтгэж зохионо.
2. Хэвлэлтэнд бэлтгэх явцдаа 2001-2010 онд улсын төсвөөр хэрэгжсэн “Монгол орны геологийн мэдээллийн сан хөтөлбөр”-ийн хэмжээнд 1:200000-ны масштабын хавтгайн хэмжээнд бэлтгэгдсэн соронзон орны зураг, олон сувгийн гаммаспектрометрийн зураг /ерөнхий цацраг идэвхжил/, мөн 1:1000000-ны масштабтаар бэлтгэгдсэн хүндийн хүчний орны зургаас хавтгай тус бүрт 1:500000-ны масштабын соронзон орон, ерөнхий цацраг идэвхжил, хүндийн хүчний орны тойм зургуудыг олон сувгийн гаммаспектрометрийн зураг /геологийн тогтоцтой уялдуулан сувгийн сонголт хийх/, ашигт малтмалын зураг болон дагалдах байдлаар минерагений дүүрэгчлэл болон хэтийн төлвийн тойм зургийг 1:500000-ны масштабтаар мөн минерагений хүчин зүйлүүдийн тодорхойлолт, дөрөвдөгчийн хурдасны зураг, экологи-геологийн зураг болон дагалдах байдлаар 1:500000-ны масштабтайгаар геоморфологийн тойм зураг, экологи-геологийн аюулын үнэлгээний тойм зураг, байгалийн дурсгалт газруудын байршлын тойм зураг, дөрөвдөгчийн хурдсын тархалтын (аллюви, пролюви, делюви-пролюви, местлөгийн хурдас, ус-местлөгийн хурдас, салхины гаралтай хурдас зэрэг геологийн зурагт тодорхой насаар тусгагддаг хурдсаас гадна геологийн зурагт тусгагдаагүй ба ангилагдаагүй дөрөвдөгчийн настай гэж тооцогддог элюви, элюви-делюви, коллюви, коллюви-делюви мэтийн хурдсын тархалтыг харуулах мөн түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалыг буулгах) тойм зургийг зохиох баримт материалын зурагт зохиогчийн төслийн хугацаанд хийсэн хээрийн судалгаа болон шинжилгээний ажлын баримт материалаас (ажиглалтын цэг, авсан сорьцууд, шинжилгээ хийлгэсэн төрөл бүрийн сорьцууд, палеонтологийн олдвор цэг г.м) гадна, өмнөх судлаачдын хийсэн ажлын баримт материалаас палеонтологийн олдвор цэг, силикатын сорьц, үнэмлэхүй нас, чухал ач холбогдолтой зүсэлт, цооног гэх мэтээр геологийн зураг зохиоход ашигласан баримт материалуудыг бүрэн буулгана. Эдгээр зургуудын дагалдах мэдээллийн санг холбогдох загвар, хэлбэрээр багцалж компьютерт “Access” программаар хийнэ. Шаардлагатай тохиолдолд мэдээллийн сангийн загварын хэлбэрт нэмэлт баяжуулалт хийнэ.

М (N) хавтгайн нэгтгэсэн зураг зохиох, дагалдах мэдээллийн санг бэлтгэх ажлыг дараах дэс дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- М (N) хавтгайн нэгтгэсэн геологийн зураг зохиох талбайн хэмжээнд хийгдсэн геологийн бүх төрлийн судалгааны фондын болон хэвлэгдсэн материалтай нарийвчлан танилцаж, дүн шинжилгээ хийх,
- Талбайн хэмжээний байр зүйн зургийн болон агаар, сансрын зургийг бэлтгэн бүрдүүлж, тайлал хийх,
- Монгол Алтай, Нуурууд, Сонгино-Тарвагатай, Хөвсгөл-Булган, Хангай-Хэнтий, Дорнод Монголын серийн легендийн хүрээнд өмнө хийгдсэн геологи-геофизик-геохимийн бүх төрлийн судалгааны материалуудад үндэслэн агаар, сансрын

зургийн тайллаар нэмж баяжуулсан М (N) хавтгайн нэгтгэсэн ажлын зураг, зураг бүрийн легендийг зохиох,

- Өмнө хийгдсэн судалгаагаар шийдвэрлэгдээгүй, маргаантай асуудал, судалгааны материалд хийсэн дүн шинжилгээгээр шалган тодруулах шаардлагатай зүйлсийг хэрхэн нэг мөр болгон шийдвэрлэх арга замыг тодорхойлсон ажлын төлөвлөгөө болон хээрийн судалгааны төлөвлөгөөг жил бүр боловсруулан Редакцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулна. Эдгээр ажлын төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилд гүйцэтгэх ажлын төрөл, тоо хэмжээг тусгасан жил бүрийн төсөл, төсвийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах,
- Хээрийн судалгаагаар сонгосон талбайн геологийн тогтцыг судлан, хил заагийн харьцааг нарийвчлах, хурдас чулуулгийн бүрэлдэхүүн, найрлагыг судалж зэргэлдээх талбайтай харьцуулах, хил заагийг уялдуулах, тектоник-структурын ажиглалт, хэмжилт хийх, дөрөвдөгчийн хурдсыг судлах, геоморфологи, экологи-геологийн ажиглалт явуулах, ашигт малтмалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүд, хувирлын бүс болон бүс, дүүрэг, талбайтай танилцах, ашигт малтмалын хувьд хэтийн төлөв бүхий талбайд эрэл-шалгалтын ажил хийх, шаардлагатай дээж, сорьцыг авах болон бусад шаардлагатай ажлуудыг гүйцэтгэх,
- Хээрийн судалгааны ажлаар баталгаажуулсан, шийдвэрлэсэн болон бусад нэмэлт мэдээллүүдийг боловсруулж, ажлын зурагт тусган өгч М (N) хавтгайн хэмжээнд нэгтгэсэн Монгол Алтай, Нуурууд, Сонгино-Тарвагатай, Хөвсгөл-Булган, Хангай-Хэнтий, Дорнод Монголын серийн легендийн хүрээнд холбогдох заавар, шаардлагыг хангасан геологийн иж бүрдэл зургийг, дагалдах бичиглэл, мэдээллийн сангийн хамт зохиох,
- Зураг зохиох явцад цуглуулсан баримт материалаар Монгол Алтай, Нуурууд, Сонгино-Тарвагатай, Хөвсгөл-Булган, Хангай-Хэнтий, Дорнод Монголын серийн легенд болон дагалдах мэдээллийн сангийн загвар, хэлбэрт оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг баримтжуулан Редакцийн зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулж, баталгаажуулах,
- Монгол Алтай, Нуурууд, Сонгино-Тарвагатай, Хөвсгөл-Булганы, Хангай-Хэнтий, Дорнод Монголын серийн легендийн дагуу, холбогдох заавар, шаардлагыг хангасан, 1:200000-ны масштабын байр зүйн хавтгай бүрээр зохиогдсон М (N) хавтгайн нэгтгэсэн геологийн зургийн иж бүрдэл зургийн зураг бүр нь легенд болон дагалдах мэдээллийн сантай байна. Зохиосон М (N) хавтгайн нэгтгэсэн геологийн иж бүрдэл зураг, тайлбар бичиг, дагалдах мэдээллийн санг Редакцийн зөвлөлөөр хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулсны үндсэн дээр зургийн хэсэгт шилжүүлж, тоон хэлбэрт хөрвүүлж зургуудыг эцсийн байдлаар 2% хэвлэж гаргах.

5. Төслийн ажлын эцсийн бүтээгдэхүүн:

Монгол орны М (N) хавтгайн хэмжээнд 1:200000-ны масштабтай иж бүрдэл зургууд нэгтгэн зохиох ажлын эцсийн бүтээгдэхүүн нь:

- Нэгтгэсэн зураг, дагалдах мэдээллийн сан, дагалдах тайлбар бичиг,
- Нийт мэдээллийн сан буюу Access-г тоон хувилбараар (CD-ээр)

6. Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа:

6.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: Шууд гэрээгээр

6.2. Хээрийн ажил:

Эхний жилд: 2020 оны 8-р сараас 10-р сарыг дуустал

Хоёр дахь жилд: 2021 оны 6-р сараас 10-р сарыг дуустал

Гурав дахь жилд: 2022 оны 6-р сараас 10-р сарыг дуустал

6.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:

2020 оны 11-р сараас 2021 оны 5-р сарыг дуустал.

2021 оны 11-р сараас 2022 оны 5-р сарыг дуустал.

Эцсийн суурин боловсруулалт:

2023 оны 9-р сарыг дуустал

6.4. Судалгааны ажлын эцсийн суурин боловсруулалтаар үр дүнгийн тайлан зохиож хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэн, Редакцын зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсны дараа шаардлагатай засвар нэмэлтүүдийг хийх

2023 оны 10-р сарыг дуустал.

6.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтнээр хянуулж шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан ирүүлэх:

2023 оны 11-р сарыг дуустал.

6.6. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулсны дараа Геологийн баримтын төв архивт тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсаны дараа ажлын 5 хоногт багтаах